



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/599

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Манай аймагт үнэ төлбөргүй эмчилгээ үйлчилгээ үзүүлэн ажилласан БНСУ-ын Бусан хотын эмнэлгийн мэс засал, зүрх судас, дотор, сувилахуйн чиглэлээр мэргэшсэн эмч, мэргэжилтэнүүд 17 хүнийг хүлээн авч уулзахад 118 000 төгрөг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдаар ахлуулсан ажлын хэсэг манай аймагт ажиллахад 557 000 төгрөг, Улаанбаатар хотод зохион байгуулсан аймгийн удирдах ажилтаны сургалт зөвлөгөөний зардалд 722 000 төгрөг, төрийн ёслолын албаны хүмүүстэй хийсэн уулзалтын зардалд 138 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1 535 000 төгрөг /Нэг сая таван зуун гучин таван мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/599 Ch

02 02979